



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 8/25

Мандалговь

Ж.Гантулгыг үнэлгээний хорооны даргаар  
нөхөн томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Инженерийн хийцтэй худаг”-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны дарга С.Адъяасүрэн /Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн мэргэжилтэн/ нь хөдөө сумдад албан томилолттой байгаа тул үнэлгээний хорооны даргаас чөлөөлсүгэй.

2. Тус ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны даргаар Орон нутгийн өмчийн газрын дарга (Ж.Гантулга)-ыг нөхөн томилсугай.

3. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Л.ДОРЖБАТ

486210418